



**ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 09. ДҮГЭЭР
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 37

Мөрөн сум

Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох,
төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэр бүрдсэн тул Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох сонгон шалгаруулах товыг 2025 оны 10 дугаар сарын 06-ний өдрөөс 11 дүгээр сарын 06-ний өдрийг хүртэл товлон зарласугай.

2. Төсөл сонгон шалгаруулах товыг холбогдох хууль, журмын дагуу иргэдэд нээлттэй мэдээллэн журамд заасан шаардлагын дагуу төсөл хүлээн авч, сонгон шалгаруулж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулах хороо (Н.Намжилноров)-нд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл (Г.Дашпүрэв)-д үүрэг болгосугай.

ДАРГА *Дашпүрэв* Ж.ДАШЖАМЦ

